

ГЭРЛЭХ ЁСЛОЛЫН ОРДОН
ОНӨААТҮГ
БАТЛАВ
ГЭРЛЭХ ЁСЛОЛЫН ОРДОН ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ *С. Цуримсүрэн* ҮҮРИЙНТУЯА

2020 оны 07 сарын 08

УЛААНБААТАР ХОТ
1115106104 2117576

Гэрлэх ёслолын ордон ОНӨААТҮГ

**КОМПЬЮТЕР, ДАГАЛДАХ ХЭРЭГСЭЛ, ВИДЕО КАМЕР
НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ
АВАХ БАРИМТ БИЧИГ**

Төслийн дугаар: ГЁО/202002005

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

БАГЦ 1- СУУРИН БОЛОН ЗӨӨВРИЙН КОМПЬЮТЕР, 3 ҮЙЛДЭЛТ ПРИНТЕР, ГАР, ХУЛГАНА/ WIRELESS/ НИЙЛҮҮЛЭХ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ

| ТӨӨЗ-ны холбогдох заалт | Шалгуур үзүүлэлт |
|-------------------------|--|
| ТӨӨЗ 1.1 | <ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн 2 жилийн /2018, 2019/ аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх 2. Сүүлийн 2 жилийн /2018, 2019/ ижил төстэй бараа нийлүүлсэн тухай мэдээлэл, гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт 3. Ижил төстэй ажлын өртөг нь сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны аль нэг жилд тухайн багцын төсөвт өртгийн 100 хувиас дээш байх. 4. Борлуулалтын орлого нь 2018, 2019 он тус бүрт тухайн багцын төсөвт өртгийн 100%-с дээш байх 5. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Санал болгож буй үнийн 80%-иас багагүй байна. <p>Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл [1] болон [2] дахь заалтын нийлбэрээр тус тус тодорхойлно. Үүнд: 1. Байгууллагын дансны үлдэгдэл /Харилцагч банкны/ 2. Арилжааны банкны зээлийн авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт /Банкны судлан үзэж зээл олгох боломжтой гэсэн тодорхойлолтыг үнэлгээнд харгалзахгүй/. 3. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг Сангийн сайдын 2015 оны 343 дугаар тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайланд шинжилгээ хийх үлгэрчилсэн загвар”-ын 3.2.2 /е/-д “Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө = Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө + Санхүүгийн хөрөнгө + Дансны авлага гэсэн үзүүлэлтүүдээр дүгнэнэ” гэж заасны дагуу тодорхойлно.</p> |
| ТӨӨЗ 2.1 | <p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, П.Гэндэнгийн гудамж-2 “Гэрлэх ёслолын ордон” Утас: 320515, Захиргааны ажилтан А.Хулан 99824824</p> <p>Огноо: 2020 оны 07 дугаар сарын 20-ний өдөр</p> <p>Цаг: 09 цаг 00 минут</p> |
| ТӨӨЗ 2.1 | <p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, П.Гэндэнгийн гудамж-2 “Гэрлэх ёслолын ордон” Утас: 320515, Захиргааны ажилтан А.Хулан 99824824</p> <p>Огноо: 2020 оны 07 дугаар сарын 20-ний өдөр</p> <p>Цаг: 09 цаг 30 минут</p> |
| ТӨӨЗ 2.3 | <p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар ирүүлэх. |

| | |
|--|--|
| | <ol style="list-style-type: none">2. Нэмэгдсэн өртөгийн албан татвар төлөгч бол гэрчилгээний хуулбар ирүүлэх.3. Харьяа дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт ирүүлэх.4. Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын тодорхойлолт ирүүлэх шаардлагагүй бөгөөд Татварын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас тендерт оролцогчийн татварын өр, төлбөрийн талаарх мэдээллийг тендер нээсэн өдрийн байдлаар шалгах тул өр, төлбөргүй байх шаардлагатай.5. Харьяа дүүргийн татварын хэлтэс, Нийгмийн даатгал болон харилцагч банк болон холбогдох эрх бүхий байгууллагуудаас тодруулга авахад татгалзах зүйлгүй гэсэн албан бичиг ирүүлнэ.6. Тухайн барааг нийлүүлэх нийлүүлэлтийн хуваарь ирүүлэх.7. Барааны чанарын сертификат /нотариатаар баталгаажуулсан/ ирүүлэх.8. Тухайн барааг худалдан борлуулах эрх бүхийг нотлох зөвшөөрөл, гэрчилгээ ирүүлэх.9. Нийлүүлэхээр санал болгосон бараандаа 1 жил болон түүнээс дээш хугацааны чанарын баталгаа гаргаж өгөх.10. Нийлүүлэхээр санал болгож байгаа бараа нь захиалагчийн техникийн тодорхойлолт болон шаардлагад бүрэн нийцсэн байх.11. Нийлүүлэхээр санал болгож байгаа барааны фото зураг, чанарын үзүүлэлт бүхий танилцуулга ирүүлэх. |
|--|--|

БАГЦ 2- МЭРГЭЖЛИЙН ВИДЕО КАМЕР НИЙЛҮҮЛЭХ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ

| ТӨӨЗ-ны холбогдох заалт | Шалгуур үзүүлэлт |
|-------------------------|--|
| ТӨӨЗ 1.1 | <ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн 2 жилийн /2018, 2019/ аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх 2. Сүүлийн 2 жилийн /2018, 2019/ ижил төстэй бараа нийлүүлсэн тухай мэдээлэл, гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт 3. Ижил төстэй ажлын өртөг нь сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны аль нэг жилд тухайн багцын төсөвт өртгийн 100 хувиас дээш байх. 4. Борлуулалтын орлого нь 2018, 2019 он тус бүрт тухайн багцын төсөвт өртгийн 100%-с дээш байх 5. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Санал болгож буй үнийн 80%-иас багагүй байна. <p>Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл [1] болон [2] дахь заалтын нийлбэрээр тус тус тодорхойлно. Үүнд: 1. Байгууллагын дансны үлдэгдэл /Харилцагч банкны/ 2. Арилжааны банкны зээлийн авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт /Банкны судлан үзэж зээл олгох боломжтой гэсэн тодорхойлолтыг үнэлгээнд харгалзахгүй/. 3. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг Сангийн сайдын 2015 оны 343 дугаар тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайланд шинжилгээ хийх үлгэрчилсэн загвар”-ын 3.2.2 /e/-д “Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө = Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө + Санхүүгийн хөрөнгө + Дансны авлага гэсэн үзүүлэлтүүдээр дүгнэнэ” гэж заасны дагуу тодорхойлно.</p> |
| ТӨӨЗ 2.1 | <p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, П.Гэндэнгийн гудамж-2 “Гэрлэх ёслолын ордон” Утас: 320515, Захиргааны ажилтан А.Хулан 99824824</p> <p>Огноо: 2020 оны 07 дугаар сарын 20-ний өдөр</p> <p>Цаг: 09 цаг 00 минут</p> |
| ТӨӨЗ 2.1 | <p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, П.Гэндэнгийн гудамж-2 “Гэрлэх ёслолын ордон” Утас: 320515, Захиргааны ажилтан А.Хулан 99824824</p> <p>Огноо: 2020 оны 07 дугаар сарын 20-ний өдөр</p> <p>Цаг: 09 цаг 30 минут</p> |
| ТӨӨЗ 2.3 | <p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар ирүүлэх. 2. Нэмэгдсэн өртөгийн албан татвар төлөгч бол гэрчилгээний хуулбар ирүүлэх. |

| | |
|--|--|
| | <ol style="list-style-type: none">3. Харъяа дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт ирүүлэх.4. Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын тодорхойлолт ирүүлэх шаардлагагүй бөгөөд Татварын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас тендерт оролцогчийн татварын өр, төлбөрийн талаарх мэдээллийг тендер нээсэн өдрийн байдлаар шалгах тул өр, төлбөргүй байх шаардлагатай.5. Харъяа дүүргийн татварын хэлтэс, Нийгмийн даатгал болон харилцагч банк болон холбогдох эрх бүхий байгууллагуудаас тодруулга авахад татгалзах зүйлгүй гэсэн албан бичиг ирүүлнэ.6. Тухайн барааг нийлүүлэх нийлүүлэлтийн хуваарь ирүүлэх.7. Барааны чанарын сертификат /нотариатаар баталгаажуулсан/ ирүүлэх.8. Тухайн барааг худалдан борлуулах эрх бүхийг нотлох зөвшөөрөл, гэрчилгээ ирүүлэх.9. Нийлүүлэхээр санал болгосон бараандаа 1 жил болон түүнээс дээш хугацааны чанарын баталгаа гаргаж өгөх.10. Нийлүүлэхээр санал болгож байгаа бараа нь захиалагчийн техникийн тодорхойлолт болон шаардлагад бүрэн нийцсэн байх.11. Нийлүүлэхээр санал болгож байгаа барааны фото зураг, чанарын үзүүлэлт бүхий танилцуулга ирүүлэх. |
|--|--|

Төсөв задаргаа

Нийт төсөвт өртөг: **34,850,000 төгрөг**

| Д/д | Тоног төхөөрөмжийн нэр | Тоо ширхэг | Төсөвт өртөг /төгрөгөөр/ | Багцын нэр, дугаар | Багцын нийт төсөв /төгрөгөөр/ |
|-------------|-------------------------------|------------|--------------------------|---|-------------------------------|
| 1 | Суурин компьютер / Иж бүрэн / | 2 | 20,610,000 | Багц 1- Суурин, зөөврийн компьютер, 3 үйлдэлт принтер | 23,060,000 |
| 2 | Зөөврийн компьютер | 1 | 2,000,000 | | |
| 3 | 3 үйлдэлт принтер | 1 | 450,000 | | |
| 4 | Мэргэжлийн видео камер | 1 | 11,790,000 | Багц 2- Мэргэжлийн видео камер | 11,790,000 |
| <i>Нийт</i> | | | | | 34,850,000 |

ГЭРЛЭХ ЭСЛӨЛЫН ОРДОН ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ

2020 оны 7 сарын 08 өдөр

УЛААНБААТАР ХОТ
1115106104 н/а 2117576

Техникийн тодорхойлолт

Багц 1- Суурин болон зөөврийн компьютер, 3 үйлдэлт принтер, гар, хулгана /wireless/

1. Суурин компьютерийн иж бүрдэл- 2 ширхэг

| Д/д | Үзүүлэлт | Баталгаат хугацаа |
|-----|---|----------------------------|
| 1 | AMD THREADRIPPER 2950WX | 1 жил ба түүнээс дээш байх |
| 2 | X399 Asus / gigabyte/ MOTHERBOARD-тэй дүйцэхүйц | |
| 3 | 64 GB DDR4 | |
| 4 | 500 GB M.2 PCI BASED SSD | |
| 5 | 4TB HDD 7200 RPM | |
| 6 | GEFORCE RTX 2080 8GB | |
| 7 | POWER SUPPLY 850W | |
| 8 | TRX 4 COOLING SYSTEM | |
| 9 | MID TOWER CASE | |
| 10 | DELL ULTRASHARP 27 MONITOR U2719H-тэй дүйцэхүйц | 1 жил ба түүнээс дээш байх |
| 11 | MOUSE, KEYBOARD / WIRELESS/ | 1 жил ба түүнээс дээш байх |

2. Зөөврийн компьютер /notebook/- 1 ширхэг

| Д/д | Үзүүлэлт | Баталгаат хугацаа |
|-----|-----------------------------------|----------------------------|
| 1 | DELL INSPIRON 5593- тэй дүйцэхүйц | 1 жил ба түүнээс дээш байх |
| 2 | I5-10 th GEN | |
| 3 | 8GB DDR4 | |
| 4 | 256GB SSD | |
| 5 | 15.6 FHD | |
| 6 | WIN10 HOME | |

3. 3 үйлдэлт / хэвлэх, хувилах, сканнер/ принтер - 1 ширхэг

| Д/д | Үзүүлэлт | Баталгаат хугацаа |
|-----|--|----------------------------|
| 1 | Printer laser, Canon image CLASS MF3010-тэй дүйцэхүйц | 1 жил ба түүнээс дээш байх |
| 2 | MONO laser print, Scan, Copy, A4, 18ppm, 600x400dpi, First print type-7.8sec, Print Capacity 250-1,000 pages, Platen10, 64MB, Cartridge 325 /1600 pages/ | |



ГЭРЛЭХ ЁСЛОЛЫН ОРДОН ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ С.ҮҮРИЙНТУЯА

2020 оны 07 сарын 08 өдөр

Багц 2- Мэргэжлийн видео камер – 1 ширхэг

| Д/д | Үзүүлэлт | Баталгаат хугацаа |
|---|--|----------------------------|
| 1 | Sony HXR-NX5R-тэй дүйцэхүйц | 1 жил ба түүнээс дээш байх |
| 2 | 1080p бичлэг | |
| 3 | 20x optical zoom / 40x digital zoom | |
| 4 | 2 SD card оролт | |
| 5 | HD филтэртэй | |
| 6 | Видео холболт - AVCHD, DV, XAVC S | |
| 7 | Аудио холболт - XLR-type 3-pin оролт - 2, чихэвч - 1 | |
| 8 | Wi-fi/NFC - MPEG-2 TS/UDP, RTPM(UPSTREAM) | |
| 9 | Камера дэлгэц – LCD 3.5 инч | |
| 10 | Баттерей - NP-F770 | |
| 11 | Жин – 2.1 кг / ойролцоогоор / | |
| Дагалдах баттерей, зориулалтын цүнхийг үнийн саналдаа багтаах | | |

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

| | Нэр | Тодорхойлолт | Тоо ширхэг | Хэмжих нэгж | ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг | Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа | | |
|--------|-------------------------------|--|------------|-------------|--|---|----------------------------------|--------------------------------------|
| | | | | | | Нийлүүлэх хамгийн эхний хугацаа | Нийлүүлэх эцсийн хугацаа | Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| Багц 1 | Суурин компьютерийн иж бүрдэл | 1. Процессор 2. Дэлгэц 3. Гар, хулгана | 2 | ширхэг | <i>Гэрлэх ёслолын ордон ОНӨААТ ҮГ</i> | Гэрээ байгуулснаас хойш ажлын 5 хоног | Гэрээ байгуулснаас хойш 21 хоног | |
| | Зөөврийн компьютер /notebook/ | Зөөврийн компьютер | 1 | ширхэг | | Гэрээ байгуулснаас хойш ажлын 5 хоног | Гэрээ байгуулснаас хойш 21 хоног | |
| | 3 үйлдэлт принтер | 3 үйлдэлт принтер | 1 | ширхэг | | Гэрээ байгуулснаас хойш ажлын 5 хоног | Гэрээ байгуулснаас хойш 21 хоног | |
| Багц 2 | Мэргэжлийн видео камер | Мэргэжлийн видео камер | 1 | ширхэг | | Гэрээ байгуулснаас хойш ажлын 5 хоног | Гэрээ байгуулснаас хойш 30 хоног | |

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

| Нэр төрөл | Тодорхойлолт | Барааны гарал үүслийн улс | Тоо ширхэг | Нэгж үнэ | Нийт дүн | НӨАТ болон бусад албан татвар | Бүгд дүн |
|--------------------|--------------|---------------------------|------------|----------|----------|-------------------------------|----------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| Тендерийн нийт үнэ | | | | | | | |

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

| Гэрээний нэр | Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс | Гэрээний үнийн дүн | Гэрээний эхлэх хугацаа | Гэрээний дуусах хугацаа |
|--------------|--|-----------------------|---------------------------|----------------------------|
| 1. | | | | |
| 2. | | | | |
| 3. | | | | |
| 4. | | | | |
| 5. | | | | |
| бусад. | | | | |

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 1 жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)**
- 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)**
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Баталгаат засвар (ГЕН-5)**
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
- 4. Төлбөр (ГЕН – 7)**
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **100** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
- 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹**
- 9.1. Алданги оногдуулах хувь: Алданги ногдуулах хэмжээ хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувь байна.
- Алдангийн нийт дүн: Алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн 10 хувь байна.

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____-наас _____ оны __ дугаар сарын ____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]